

**Golomt Capital<sup>®</sup>**

# ДЭЛХИЙН

---

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**

**2025.08.04**

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- Зарим индексүүдийн хувьд 4 дүгээр сард тарифын нөлөөгөөр үүссэн хүчтэй уналтаас хойших хамгийн хүчтэй уналт боллоо.
- S&P 500 индексийн бүрэлдэхүүнд багтдаг компаниудын 66% нь тайлангаа танилцуулсан бөгөөд тэдгээрийн 82% нь шинжээчдийн ашигт таамаглалыг давж, нийлмэл орлогын өсөлт 10.3%-д хүрсэн байна.
- АНУ-ын Холбооны Нөөцийн Сан долдугаар сарын мөнгөний бодлогын хурлаа лхагва гарагт дуусгаж, хүлээгдэж байсны дагуу бодлогын хүүгийн зорилтот хүрээг 4.25%-аас 4.50%-ийн хооронд хэвээр хадгаллаа.
- 6 дугаар сард инфляц эрчимжсэн байна.
- Хоёрдугаар улиралд АНУ-ын эдийн засаг 3%-иар өссөн.
- (PMI) долдугаар сард 49.5 болж, 50 гэсэн босго түвшнээс доошилсон нь зургадугаар сарын 50.4-өөс муудсан үзүүлэлт юм.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

|                     |              |
|---------------------|--------------|
| Deutsche Bank       | 7,000        |
| Société Générale    | 6,750        |
| BMO Capital Markets | 6,700        |
| Bank of America     | 6,666        |
| Barclays            | 6,600        |
| RBC Capital Markets | 6,600        |
| Wells Fargo         | 6,500        |
| Citigroup           | 6,500        |
| Goldman Sachs       | 6,500        |
| Morgan Stanley      | 6,500        |
| JPMorgan Chase      | 6,500        |
| UBS                 | 6,400        |
| <b>Дундаж</b>       | <b>6,678</b> |

# TARIFFS





## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.07.28-08.03

### ТАРИФ, ХУДАЛДААНЫ БОДЛОГООС ҮҮДЭН ЗАХ ЗЭЭЛ УНАЛАА.

АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өнгөрсөн долоо хоногийг алдагдалтайгаар өндөрлүүлж, зарим индексүүдийн хувьд 4 дүгээр сард тарифын нөлөөгөөр үүссэн хүчтэй уналтаас хойших хамгийн хүчтэй уналт боллоо. Хамгийн их нөлөөлсөн хүчин зүйл нь худалдааны хэлэлцээр болон тарифын асуудлууд байв. Ерөнхийлөгч Дональд Трампын худалдааны гэрээ байгуулах 8-р сарын 1 хугацаа дөхөхийн хэрээр энэ асуудал анхаарлын төвд байв. Пүрэв гарагт Трамп АНУ-ын худалдааны ихэнх түншүүдэд тавих тарифыг 8-р сарын 7-ны өдрөөс эхлэн нэмэгдүүлэх захирамжид гарын үсэг зурсан нь баасан гарагийн өглөөний зах зээлийн уналтад хүчтэй нөлөөлжээ. Европын Холбоо болон Өмнөд Солонгостой шинэ гэрээ байгуулсан бөгөөд Мексиктэй хийх хэлэлцээрийн хугацааг дахин 90 хоногоор сунгасан тухай зарим мэдэгдэлүүд гарчээ.

Мөн ашгийн тайлангууд зах зээлийн анхаарлын төвд байв. FactSet-ийн мэдээлснээр, баасан гарагийн өглөөний байдлаар S&P 500 индексийн бүрэлдэхүүнд багтдаг компаниудын 66% нь тайлангаа танилцуулсан бөгөөд тэдгээрийн 82% нь шинжээчдийн ашигт таамаглалыг давж, нийлмэл орлогын өсөлт 10.3%-д хүрсэн байна. Гэвч зарим компаниуд тарифын дарамтаас шалтгаалан бизнес нь хүндрэлтэй тулгарч байгааг анхааруулжээ. Жишээлбэл, Ford Motor энэ жил тарифын улмаас 2 тэрбум ам.долларын алдагдал хүлээхээр байгаагаа мэдэгдсэн. Харин Microsoft болон Meta Platforms компаниудын хувьцаа таамгаас давсан санхүүгийн үр дүнгийн дараа өсч, хиймэл оюун ухаан тэдний үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж байгааг онцолжээ.

АНУ-ын Холбооны Нөөцийн Сан долдугаар сарын мөнгөний бодлогын хурлаа лхагва гарагт дуусгаж, хүлээгдэж байсны дагуу бодлогын хүүгийн зорилтот хүрээг 4.25%-аас 4.50%-ийн хооронд хэвээр хадгаллаа. Гэсэн хэдий ч хоёр гишүүн санал зөрж, бодлогын хүүг 0.25 нэгжээр бууруулахыг дэмжсэн байна. Хурлын дараах мэдэгдэлд "эдийн засгийн идэвхжил оны эхний хагаст саарсан" гэж дурдсан нь зарим зах зээлийн оролцогчд үүнийг зөөлөн буюу "dovish" хандлага гэж үзэв. Харин хурлын дараах хэвлэлийн бага хурлын үеэр Холбооны Нөөцийн Сангийн дарга Жером Пауэлл инфляц зорилтот түвшнээс өндөр хэвээр байгааг онцолж, төв банк бодлогын шийдвэр гаргахдаа эдийн засгийн мэдээллийг үргэлжлүүлэн харгалзан үзэх болно гэж мэдэгдсэн. Энэ нь зах зээлийн хандлагыг өөрчилж, есдүгээр сард хүүг бууруулах хүлээлтийг бууруулав.

Үүний зэрэгцээ Пүрэв гарагт АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчооноос нийтэлсэн мэдээллээр 6 дугаар сард инфляц эрчимжсэн байна. ВЕА-ийн тооцоолдог, Холбооны Нөөцийн Сангийн хамгийн чухалчилдаг инфляцын үзүүлэлт болох "үндсэн хувийн хэрэглээний зардлын индекс" (core PCE) 6 дугаар сард сарын өмнөхөөсөө 0.3%-иар өссөн нь 5 дугаар сарын 0.2%-тай харьцуулахад хурдассан үзүүлэлт юм. Жилийн дүнгээрээ инфляц 2.8%-д хүрч, төв банкны урт хугацааны зорилтот 2%-иас давсан хэвээр байна.

Мөн хоёрдугаар улиралд АНУ-ын эдийн засаг 3%-иар өссөн гэж мэдээлсэн нь эхний улиралд бүртгэгдсэн 0.5%-ийн уналтаас эрс дээрдсэн үзүүлэлт юм. Энэхүү өсөлт нь импортын огцом бууралтаас ихээхэн хамаарсан бөгөөд импортын бууралт нь дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) тооцоололд хасалт болж ордог онцлогтой.



**Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.07.28 – 08.03**

**ХЯТАДЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ӨСЛӨӨ.**

АНУ шинэ тарифын хэмжээг зарласны дараа дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв бүрхэг болсон. Нэмээд Хятадын эдийн засгийн удаашралтай холбоотой хэд хэдэн үзүүлэлт нийтлэгдсэн нь эх газрын Хятадын хөрөнгийн зах зээлийг уналтад хүргэв. FactSet-ийн мэдээлснээр, Хятадын дотоодын гол индекс болох CSI 300 индекс 1.75%-иар, Shanghai Composite индекс 0.94%-иар буурсан бол Хонконгийн Hang Seng индекс 3.47%-ийн уналттай байлаа.

S&P Global байгууллагын Хятадын үйлдвэрлэлийн худалдан авагч менежерийн индекс (PMI) долдугаар сард 49.5 болж, 50 гэсэн босго түвшнээс доошилсон нь зургадугаар сарын 50.4-өөс муудсан үзүүлэлт юм. Энэхүү хувийн PMI судалгаа нь шинжээчдийн хүлээлтээс доогуур гарсан бөгөөд өмнөх өдөр нийтлэгдсэн албан ёсны PMI мөн 49.3 болж, гурван сарын доод түвшинд хүрсэн. Бүх үзүүлэлтүүд шинжээчдийн таамгаас муу гарсан. Хятадын статистикийн газраас пүрэв гарагт мэдээлэл хийхдээ долдугаар сард үйлдвэрлэл суларсан шалтгааныг зарим бүс нутагт үүссэн халуун агаар, хүчтэй аадар бороо, үерийн улмаас үйлдвэрлэл доголдсоныг дурдсан байна.

Хамгийн сүүлийн PMI үзүүлэлтүүд нь ойрын саруудад Хятадын эдийн засгийн өсөлт саарах хандлагатай байгааг харуулж байна. Дотоодын зах зээлийн эрэлт сул хэвээр байгаагаас гадна олон улсын худалдааны тодорхой бус байдал нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байгаа юм. Оны эхний хагаст Хятадын эдийн засгийг сэргээхэд АНУ-ын тарифын өсөлтийн өмнөх экспортын “урьдчилсан ачилт”, АНУ-аас бусад зах зээл рүү чиглэсэн нийлүүлэлт, дотоодын төсвийн тэлэлтийн бодлого зэрэг хүчин зүйлс дэмжлэг байсан. Гэвч эдгээр эерэг нөлөөнүүдийн үр дүн буурах тусам эдийн засгийн өсөлтийн хурдац саарах хандлагатай гэж олон эдийн засагч үзэж байна.



**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**

| Monday      |             | Tuesday     |             | Wednesday   |             | Thursday    |             | Friday      |
|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|
| Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |

http://eps.sh/cal

© 2025 Earnings Whispers

**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**

| Monday      |             | Tuesday     |             | Wednesday   |             | Thursday    |             | Friday      |
|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|
| Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |
|             |             |             |             |             |             |             |             |             |

http://eps.sh/cal

© 2025 Earnings Whispers